



КРЕДИТ
ББСБ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 30-ны өдөр

Дугаар 01/21

Улаанбаатар хот

2020 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2021 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 21/02 тоот тогтоолыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2021 оны 4 сарын 30-ны өдөр

Дугаар 02/21

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 2021 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 21/04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр

Одончимэд овогтой Одбаяр;
Хишигдорж овогтой Батхишиг;
Гэрэлт овогтой Тэлмэн нарыг,

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

Чулуунзоригт овогтой Чинзоригт;
Батсүрэн овогтой Солонго нарыг тус тус томилохыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (М.Мөнхсүрэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2021 оны 4 сарын 30-ны өдөр

Дугаар 03/21

Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулан батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2021 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 21/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийг нэмэлт, өөрчлөлт оруулан нэгдүгээр Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан дүрмийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн хянуулж, Улсын бүртгэлийн газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ